



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/362

Булган сум

Дотоодын их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа оюутны тэтгэлэгт хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8, Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 онд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хамрагдан дотоодын их, дээд сургуульд элсэн суралцаж байгаа, сургалтын төлбөрийн хичээлийн жилийн сүүлийн хагаст олгох тэтгэлэг олгогдоогүй Отгондорж овогтой Ариунтуяад тэтгэлгийг нөхөн олгосугай.

2.Сургалтын төлбөрийн тэтгэлэгт шаардлагатай 3,570,000 (гурван сая таван зуун далан мянга) төгрөгийг хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

